

БХИС-ийн Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн нь БНСУ-ын Батлан хамгаалах яамны дэргэдэх Батлан хамгаалахын дүн шинжилгээний хүрээлэн (KIDA)-тэй байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд 2011 оны 6 дугаар сарын 26-30 нд Улаанбаатар хотноо **“Зүүн хойд Азийн аюулгүй байдал: Монгол – Солонгос улсын хамтын ажиллагаа”** сэдвээр олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулав.

Энэ удаагийн хуралыг нээж БХИС-ийн захирал, доктор, профессор, бригадын генерал З.Болдбаатар уг хэлж “Зүүн хойд Азийн аюулгүй байдал ба Умард Солонгосын цомийн зэвсгийн асуудал” сэдвээр Батлан хамгаалахын дүн шинжилгээний хүрээлэнгийн ахлах судлаач Сү, Чо-Сүк, “Зүүн хойд Азид аюулгүй байдлын механизм бүрдүүлэх боломж” БХЭШХ-ийн захирал, бригадын генерал Б.Даваадорж, “Солонгосын хойгт энх тайван тогтоох болон хоёр солонгосын зэвсгийн хяналтын асуудал” сэдвээр Батлан хамгаалахын дүн шинжилгээний хүрээлэнгийн судлаач, дэд хурандаа Ким, Жэй-Хонг, “Солонгосын хойгийн оноогийн байдал ба монгол улсын бодлого, байр суурь” сэдвээр Стратеги судалгааны хүрээлэнгийн судлаач Н.Доржсүрэн, “Монгол Солонгосын энхийг дэмжих ажиллагааны салбар дахь хамтын ажиллагаа, хэтийн толов” сэдвээр БХДШХ-ийн судлаач Бү, Хёонг-Вүк, “Монгол Солонгосын эдийн засгийн хамтын ажиллагаа, цаашдын чиг хандлага” сэдвээр Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн судлаач Л.Эрдэнэбаяр нар тус тус илтгэл тавьж хэлэлцүүлэв.